



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 6 сарын 20 өдөр

Дугаар 5/79

Хэрлэн сум

С.Хуланд сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4, 48.1.1 дахь заалт, Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 3.6, 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн Банзарсүрэнгийн Хуланд сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.С.Хулангийн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт холбогдох журмын дагуу баяжилт хийхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ш.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

3.Төрийн албаны тухай хууль болон, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын дотоод журмыг сахиж өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллахыг С.Хуланд үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ч.Баярцолмон)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНТУЛГА

